БАТЛАВ:
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
С.ЖАВХЛАНБААТАР

ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРКИЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН САНГ БАЙГУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

ATA14031 9129294
9024120060

2025 оны 04 дугаар сарын 07-ны өдөр Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Эрх зүйн үндэслэл: "Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай" хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2-т үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь "дэвшилтэт техник, технологийн судалгаа хийх, бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ, эрэлт хэрэгцээний хэтийн төлөвийг тодорхойлох зорилгоор паркийн мэдээллийн сан үүсгэх, хөтлөх, холбогдох журмыг батлах" эрхийг хэрэгжүүлэхээр заасныг үндэслэн Мэдээллийн санг Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, Нийгмийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хууль болон бусад эрх зүйн актад нийцүүлнэ.

1.2. Зорилго ач холбогдол: Үйлдвэрлэл, технологийн паркийн мэдээллийн цахим дэд бүтцийг үүсгэн байгуулах, мэдээлэл цуглуулах төрөлжүүлэн хадгалах, мэдээллийн санг загварчлан өгөгдлийн цахим системд боловсруулах, дүн шинжилгээ хийх, бодлогод чиглэсэн суурь судалгаа хийх болон түүнд тулгуурлан шийдвэр гаргах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, үйлдвэр технологийн паркийн ажиллагааг цахим хэлбэрээр нээлттэй ил тод шуурхай явуулах төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгоно.

1.3. Хамрах хүрээ: Мэдээллийн сан нь мэдээллийн системд оруулах, боловсруулах ашиглах гэсэн үндсэн гурван төрлийн хэрэглэгчидтэй байх ба хэрэглэгчдийн хандалтын хүрээ болон өгөгдөл солилцох үйл ажиллагааг зохицуулах эрх бүхий системийн ерөнхий болон туслах admin-ы үйл ажиллагааг хамаарвал зохино.

Хоёр. Үндсэн шаардлага

2.1. Монгол Улсад байгуулагдахаар төлөвлөгдсөн болон байгуулагдан үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрлэл, технологийн паркууд, түүний нэгж, харьяа үйлдвэрүүд, улсын эдийн засгийн хөгжилд нөлөө бүхий томоохон боловсруулах үйлдвэрүүдтэй холбоотой мэдээллийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын А/361 дүгээр тушаалын хавсралт "Хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт хөтлөх журам"-ын дагуу дараах мэдээллийг цуглуулж, хадгална. Үүнд:

2.1.1. хүнд үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн паркийн болон боловсруулах үйлдвэртэй холбоотой хууль тогтоомж, стандарт, норм, норматив, төрийн байгууллага, албан тушаалтнаас гаргасан холбогдох эрх зүйн акт;

2.1.2. хүнд үйлдвэр байгуулах шийдвэр, ашиглалтад орсон огноо, тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээлэл, байршил, эзэмшил газрын хэмжээ, үйл ажиллагааны чиглэл, өмчийн хэлбэр, тусгай зөвшөөрөл авсан огноо;

2.1.3. үйлдвэрийн техник эдийн засгийн үндэслэл;

2.1.4. үйлдвэрийн техник, технологийн түвшний үнэлгээ;

2.1.5. байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан;

2.1.6. хөгжлийн төлөвлөгөө;

2.1.7. үйлдвэрийн нутаг дэвсгэрийн кадастрын зураг;

2.1.8. дэд бүтцийн судалгаа, тайлан, техникийн нөхцөл, хангамжийн зураг схем;

2.1.9. үйлдвэрийн инженерийн шугам сүлжээний зураг төсөл;

2.1.10. тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө, тайлан;

2.1.11. төр болон хувийн хэвшил банк санхүүгийн байгууллагаас авсан дэмжлэг, зээл, санхүүжилт, тайлан;

2.1.12. татварын хөнгөлөлтийн талаарх мэдээлэл, тайлан;

2.1.13. паркт нэгжээр орох гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн жагсаалт;

2.1.14. үйл ажиллагаа явуулж буй нэгжүүдийн тоо, эзэмшил газрын хэмжээ;

2.1.15. хүчин чадал, үйлдвэрлэл, борлуулалт, экспорт, импортын мэдээлэл;

2.1.16. ажиллах хүчний мэдээлэл;

2.1.17. хөрөнгө оруулалтын хэмжээ, төрөл, эх үүсвэр;

2.1.18. паркийн болон Үйлдвэрийн тухайн жилийн үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө, гүйцэтгэл;

2.1.19. төрийн өмчит Паркийн болон Үйлдвэрийн тухай жилийн санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт, холбогдох төрийн байгууллагын хяналт шалгалтын тайлан;

2.1.20. хуулиар нууцад хамааруулаагүй бусад мэдээлэл;

Гурав. Техникийн шаардлага

3.1. Мэдээллийн сангийн цахим систем нь төрийн мэдээлэл солилцооны систем (ХУР), танилт нэвтрэлтийн систем (ДАН), төрийн байгууллагын мэдээллийн сантай мэдээлэл солилцох боломжтой байна.

3.2. PDF өргөтгөлтэй, тоон өгөгдөл, зураг, график, бичгийн хэлбэртэй, веб орчны газарзүйн мэдээллийн системд тулгуурласан байх. Газар зүйн солбицлын WGS-84 систем, тоон өгөгдлийн Microsoft Excel программд хөрвүүлэх боломжтой байна.

3.3. Мэдээллийн санд хадгалагдаж байгаа мэдээ, тоо баримт болон бусад мэдээлэлд өөрчлөлт оруулахад боломжтой байна.

3.4. Мэдээллийн санд агуулагдаж буй нээлттэй өгөгдлийг машинд уншигдах бүтэцтэй өөрийн цахим хуудсанд болон төрийн нээлттэй өгөгдлийн порталд ангилан ялгаж, сонголт хийж ил тод байршуулах боломжтой байна.

3.5. Мэдээллийн санд нэвтрэх, мэдээлэл засварлах эрхийг зөвхөн эрх бүхий ажилтнууд эзэмших. Админ нь эрх бүхий ажилтнуудад сангийн хэсэг, цэс бүрээр хандах, өгөгдөл нэмэх, засварлах эрх үүсэх боломжтой байна.

3.6. Мэдээллийн сан нь ангилал, код, тайлбартай, өгөгдөл тус бүрийг үгээр хайлт хийх, үсгийн болон тоон дараалаар эрэмбэлэх боломжтой байна.

3.7. Мэдээллийн санг гамшиг, эрсдэлээс хамгаалах удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй байна.

3.8. Мэдээллийн сангийн логик болон физик загвар боловсруулна. (ERD диаграмм)

3.9. Веб орчны газарзүйн мэдээллийн системийг хөгжүүлнэ.

3.10. Цахим мэдээллийн сангийн программ хангамж хөгжүүлнэ.

3.11. Өгөгдлийн бүрэн бүтэн байдлыг шалгах туршилтууд хийх боломжтой байна.

3.12. Цахим системийн оновчтой бүтэц загварыг танилцуулах хэрэглээнд нэвтрүүлнэ.

3.13. Паркийн мэдээллийн санд шаардлагатай программ хангамж, компьютер, тоног төхөөрөмжийг нийлүүлнэ.

3.14. Мэдээллийн санг ашиглах, түүний хадгалалт, хамгаалалт, нууцлалын найдвартай байдлыг хангах ажиллагаа нь "Төрийн болон албаны нууцын тухай хууль", "Байгууллагын нууцын тухай хууль", "Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль", "Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль" болон Засгийн газрын 2022 оны 196 дугаар тогтоолоор батлагдсан "Үндсэн системийн үйл ажиллагааг зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам, Засгийн газрын 2023 оны 224 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан "Кибер аюулгүй байдлыг хангах нийтлэг журам" зэрэг Монгол Улсын холбогдох хууль, дүрэм, журамд нийцсэн байна.

Дөрөв. Мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээлэл төвлөрүүлэх байгууллагуудын үүрэг

4.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэгжийн үүрэг:

4.1.1. мэдээллийн санг зохион байгуулж хөтлөх, хэвийн ажиллагааг хангах;

4.1.2. цахим хуудсанд мэдээлэл байрлуулах, шинэчлэх, өөрчлөх, устгах эрхийг албан ёсны эх сурвалжийг үндэслэн зөвхөн эрх бүхий ажилтан эзэмших;

4.1.3. мэдээллийн сангаар дамжуулан лавлагаа, мэдээллээр иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад үйлчлэх;

4.2. Паркийн удирдлага, нэгж, судалгаа хөгжлийн байгууллагын үүрэг:

4.2.1. шаардлагатай мэдээллийг тухай бүрд мэдээллийн санд оруулах;

4.2.2. өгөгдлийн үнэн зөв байдлыг баталгаажуулах, хариуцах;

Тав. Ажлын хугацаа, үр дүн

5.1. Төслийн хэрэгжүүлэх хугацаа: 3 сар (90 хоног)

5.1.1. Эхлэх: 2025 оны..... дугаар сарын .....-ны өдөр

5.1.2. Дуусах: 2025 оны..... дугаар сарын .....-ны өдөр

5.2. Үйлдвэрлэл, технологийн паркийн “МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН НЭГДСЭН МАЯГТ”-ын дагуу бүтцийн загвар боловсруулж захиалагчид танилцуулна.

5.3. Цахим системийг туршиж чанарын хяналт хангасны дараа эх кодын хамт захиалагчид хүлээлгэн өгнө.

5.4. Туршилт гүйцэтгэх явцад ямар нэгэн алдаа илэрсэн тохиолдолд залруулах холбогдох гарын авлага, сургалт зохион байгуулна.

Үйлдвэрлэл, технологийн паркийн мэдээллийн
нэгдсэн санг байгуулах ажлын даалгаврын хавсралт маягт

д/д1	д/д1	д/д1	д/д1	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга	Тайлбар
1	2	3	4	5	6	7	8
1				**Ерөнхий мэдээлэл**			
	1			Аж ахуйн нэгжийн нэр		Авто	Хур системд холбогдсон
	2			Улсын бүртгэлийн дугаар		Авто	Хур системд холбогдсон
	3			Регистрийн дугаар		Авто	Хур системд холбогдсон
	4			Тусгай зөвшөөрлийн дугаар		Авто	Хур системд холбогдсон
	5			Боловсруулах үйлдвэрийн төрөл		Авто	Хур системд холбогдсон
	6			Үйлдвэрийн нэр		Авто	Хур системд холбогдсон
	7			Төслийн байршил			
		1		Аймаг / Нийслэл		Авто	
		2		Сум / Дүүрэг		Авто	
	8			Техик эдийн засгийн үндэслэл			ЭБМЗ-ийн хурлаар хэлэлцэх явцад бүртгэгдсэн мэдээлэл
		1		Төсөл боловсруулагч аж ахуйн нэгжийн нэр		Авто	
		2		Мэргэшсэн, Зөвлөх инженерийн нэр		Авто	
		3		Шинжээчийн нэр		Авто	
		4		Хүчин чадал		Авто	
		5		Бүтээгдэхүүний хэмжээ		Авто	
		6		ТЭЗҮ-ийн хүчин чадал		Авто	
		7		Хөрөнгө оруулалтын хэмжээ		Авто	
		8		Ажиллах хүчний тоо		Авто	
		9		Түүхий эдийн хэмжээ		Авто	
		10		Бүтээгдэхүүний хэмжээ		Авто	
		11		ЭБМЗ-ийн ТЭЗҮ-ийн дүгнэлтийн огноо		Авто	
		12		ЭБМЗ-ийн ТЭЗҮ-ийн дүгнэлтийн дугаар		Авто	
		13		АМГТГ-ын даргын ТЭЗҮ-ийн тушаалын огноо		Авто	
		14		АМГТГ-ын даргын ТЭЗҮ-ийн тушаалын дугаар		Авто	
		15		Төслийн нийт ашиглалтын хугацаа	Жил	Номер	
2				**Боловсруулалт/**			
	1			Технологийн туршилтын тайлан			
		1		Гүйцэтгэсэн байгууллагын нэр		Авто	
		2		Тайлангийн нэр		Текст	
		3		Туршилт хийсэн огноо	Огноо	Дата	
	2			Баяжуулах технологи		Текст	
	3			Баяжуулах үйлдвэрийн хүчин чадал	мян.тн/жил, мян.м3/жил		
	4			Үйлдвэрийн хүчин чадал юунд суурилсан бэ?		Текст	
	5			Боловсруулах түүхий эд			

		1		Нийт боловсруулах түүхий эдийн хэмжээ			
		2		Боловсруулах хүдрийн хэмжээ			
		3		Боловсруулах хүдэр дэх металл (эрдэс)-ийн хэмжээ			
		4		Боловсруулах хүдэр дэх металл (эрдэс)-ийн агуулга			
	6			Дундаж металл авалт	%	Хувь	
	7			Дундаж гарц	%	Хувь	
	8			Бүтээгдэхүүн гаргалт			
		1		Бүтээгдэхүүний хэмжээ			
		2		Бүтээгдэхүүн дэх металл (эрдэс)-ийн хэмжээ			
		3		Бүтээгдэхүүн дэх металл (эрдэс)-ийн агуулга			
	9			Урвалж, туслах материалын хэсэг			
		1		Урвалжийн нэр, хэмжээ			
	10			Хаягдлын аж ахуй			
		1		Хаягдлын төрөл			
		2		Хаягдлын хэмжээ			
		3		Хаягдал дахь металл (эрдэс)-ийн хэмжээ			
		4		Хаягдал дахь металл (эрдэс)-ийн агуулга			
		5		Хаягдал усны цэвэржүүлэлт			
		6		Хаягдлын сангийн эзэлхүүн	Мян.м3		
3				**Дэд бүтэц**			
	1			Эрчим хүч			
		1		Цахилгааны эх үүсвэр			
		2		Эрчим хүчний системд холбогдох эсэх			
			1	Төслийн хүрээнд аль системтэй холбогдох			
			2	Холбогдох зай	Км		
			3	Цахилгаан дамжуулах агаарын шугам	кВт.ц/жил (kWh/year)		
		3		Тосгоны суурилагдсан чадал	кВт (kW)		
		4		Боловсруулах үйлдвэрийн суурилагдсан чадал	кВт (kW)		
		5		Цахилгааны нийт хэрэглээ	М3		
	2			Усан хангамж	М3		
		1		Цэвэр усны эх үүсвэр	М3		
		2		Хүн амын унд, ахуйн зориулалтаар ашигласан хэрэглээ	М3		
		3		Боловсруулах үйлдвэрийн хэрэглээ	М3		
			1	Эргэлтийн усны хэмжээ	М3		
			2	Нэмэлт цэвэр усны хэмжээ	М3		
		4		Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлтэд хэрэглэх хэрэглээ	М3		
		5		Бусад (Авто зам, Барилга, Хүнд, хөнгөн, хүнсний үйлдвэрлэл, Эрчим хүч, Газар тариалан г.м)	М3		
		6		Усны нийт хэрэглээ	М3		
		7		Үйлдвэрийн эргэлтийн усны эзлэх хэмжээ	%		
	3			Гадаад тээвэр			

		1		Зам ашиглалт	Км		
			1	Орон нутгийн зам ашиглах (ердийн шороон зам)	Км		
			2	Сайжруулсан шороон зам ашиглах	Км		
			3	Хатуу хучилттай зам ашиглах	Км		
			4	Төмөр зам ашиглах	Км		
			5	Агаарын зам ашиглах	Км		
			6	Өртөө, боомтын мэдээлэл	Км		
		2		Үйлдвэрээс - Өртөө-1	Км		
			1	Өртөө-1 - Боомтын нэр	Км		
		3		Төслийн хүрээнд баригдах замын ажил	Км		
			1	Сайжруулсан шороон зам барих	Км		
			2	Хатуу хучилттай зам барих	Км		
			3	Төмөр зам барих	Км		
		4		Дулаан хангамж			
			1	Дулаан хангамжийн эх үүсвэр			
			2	Дулааны хэрэглээ	Гкал		
		5		Нийт түлш зарцуулалт	Мян.төг		
			1	Бензин	Мян.төг		
			2	Дизель түлш	Мян.төг		
4				**Байгаль орчин хамгаалах, нөхөн сэргээлт**			
	1			Техникийн нөхөн сэргээлт	Га		
		1		овоолго1	Га		
		2		овоолго2	Га		
	2			Биологийн нөхөн сэргээлт	Га		
		1		Шимт хөрс	Га		
		2		Биологийн	Га		
	3			Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээлт	Га		
5				**Ажиллах хүч, ажлын байрны нөхцөл**			
	1			Нийт ажиллагсад	Хүн	тоо	
	2			Үндсэн компани	Хүн	тоо	
		1		Үндсэн нийт ажилчид	Хүн	тоо	
			1	Үндсэн ажилчид	Хүн	тоо	
			2	Гэрээт ажилчид	Хүн	тоо	
		2		Эмэгтэй /ИТА/	Хүн	тоо	
		3		Эмэгтэй /бусад/	Хүн	тоо	
		4		Орон нутгийн ажилчид	Хүн	тоо	
		5		Гадаад	Хүн	тоо	
		6		Инженер техникийн ажилтан	Хүн	тоо	
		7		Оператор	Хүн	тоо	
		8		Бусад	Хүн	тоо	
	3			Туслан гүйцэтгэгч	Хүн	тоо	

		1		үндсэн ажилчид	Хүн	тоо	
			1	Үндсэн ажилчид	Хүн	тоо	
			2	Гэрээт ажилчид	Хүн	тоо	
		2		Эмэгтэй /ИТА/	Хүн	тоо	
		3		Эмэгтэй /бусад/	Хүн	тоо	
		4		Орон нутгийн ажилчид	Хүн	тоо	
		5		Гадаад	Хүн	тоо	
		6		Инженер техникийн ажилтан	Хүн	тоо	
		7		Оператор	Хүн	тоо	
		8		Бусад	Хүн	тоо	
	4			Ажлын байрны нөхцөл	Хүн	тоо	
		1		Хэвийн	Хүн	тоо	
		2		Хэвийн бус	Хүн	тоо	
			1	Хортой	Хүн	тоо	
			2	Хүнд	Хүн	тоо	
			3	Халуун	Хүн	тоо	
			4	Газар дор	Хүн	тоо	
			5	Бусад	Хүн	тоо	
6				**Эдийн засаг**			
	1			Хөрөнгө оруулалт	Сая.төг		
		1		Боловсруулах үйлдвэр	Сая.төг		
		2		Хаягдлын аж ахуй	Сая.төг		
		3		Дэд бүтэц	Сая.төг		
		4		Хотхон	Сая.төг		
		5		Төв оффис	Сая.төг		
		6		бэлтгэл ажил	Сая.төг		
		7		Туршилт судалгаа	Сая.төг		
		8		Эргэлтийн хөрөнгө	Сая.төг		
		9		Балансын үлдэгдэл өртөг	Сая.төг		
		10		Хөрөнгө оруулалтын эх үүсвэр	Сая.төг		
			1	Өөрийн	Сая.төг		
			2	Зээл	Сая.төг		
			3	Үнэт цаасны	Сая.төг		
			4	Бусад	Сая.төг		
	2			Орлого	Сая.төг		
		1		Нийт борлуулах бүтээгдэхүүний хэмжээ			
			1	Борлуулах бүтээгдэхүүн нэр, төрөл, хэмжээ			
			2	Борлуулах бүтээгдэхүүн дэх металл (эрдэс)-ийн хэмжээ			
			3	Борлуулах бүтээгдэхүүний агуулга			
		2		Дотоодод борлуулах бүтээгдэхүүний экспорт			
			1	Дотоодод борлуулах бүтээгдэхүүний хэмжээ			

			2	Дотоодод борлуулах бүтээгдэхүүн дэх металл (эрдэс)-ийн хэмжээ			
			3	Дотоодод борлуулах бүтээгдэхүүний агуулга			
		3		Экспортлох бүтээгдэхүүний хэмжээ			
			1	Экспортлох бүтээгдэхүүний хэмжээ			
			2	Экспортлох бүтээгдэхүүн дэх металл (эрдэс)-ийн хэмжээ			
			3	Экспортлох бүтээгдэхүүний агуулга			
		4		Валютын ханш	төг/$, төг/юань ...		
		5		Бүтээгдэхүүний жишиг үнэ	Сая.төг		
		6		Борлуулалтын үнэлгээ	Сая.төг		
		7		Борлуулах бүтээгдэхүүний бодит үнэ	Сая.төг		
		8		Борлуулах бүтээгдэхүүний металлын бодит үнэ	Сая.төг		
		9		Бүтээгдэхүүний борлуулалтын орлого	Сая.төг		
		10		Бусад орлого	Сая.төг		
		11		Нийт орлого	Сая.төг		
	3			Зардал	Сая.төг		
		1		Үйлдвэрлэлийн зардал	Сая.төг		
			1	Байгаль орчныг хамгаалах зардал	Сая.төг		
			2	Цалин	Сая.төг		
			3	Тэсэлгээний зардал	Сая.төг		
			4	Эрчим хүч	Сая.төг		
			5	Түлш шатахуун	Сая.төг		
			6	Сэлбэг хэрэгсэл	Сая.төг		
			7	ХАБЭА-н зардал	Сая.төг		
			8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	Сая.төг		
			9	Тээврийн зардал	Сая.төг		
			10	Түрээсийн төлбөр	Сая.төг		
			11	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл	Сая.төг		
			12	Материалын зардал	Сая.төг		
			13	Хувь хөрөнгөөр хийсэн хайгуулын ажлын зардал	Сая.төг		
			14	Татварын зардал	Сая.төг		
			15	Үйлдвэрлэлийн бусад зардал	Сая.төг		
		2		Үйлдвэрлэлийн бус зардал	Сая.төг		
			1	Захиргааны зардал	Сая.төг		
			2	Зээлийн хүү	Сая.төг		
			3	Үйлдвэрлэлийн бус бусад зардал	Сая.төг		
		3		Зардлын хуваарилалт	Сая.төг		
			1	Баяжуулах (боловсруулах) үйлдвэр	Сая.төг		
			2	хотхон	Сая.төг		
			3	Дэд бүтэц	Сая.төг		
			4	Гадаад тээвэрлэлт	Сая.төг		
			5	Ерөнхий удирдлага	Сая.төг		

		4		Өөрийн өртөг, тариф	Сая.төг		
			1	Нэгж бүтээгдэхүүний өөрийн өртөг	төг/м3, төг/тн, төг/гр		
			2	Нэгж баяжуулалт /боловсруулалт/-ын өөрийн өртөг	төг/м3, төг/тн, төг/гр		
			3	Цахилгаан эрчим хүчний үнэ тариф (НӨАТ-гүй)	төг/кВт.ц		
		5		Цалин			
			1	Ажиллагсдын нэг сарын дундаж цалин	Мян.төг		
			2	Инж.тех-ийн ажилтан /1хүн/	Мян.төг		
			3	Оператор /1хүн/	Мян.төг		
			4	Гадаад /1хүн/	Мян.төг		
			5	Бусад ажилтан /1хүн/	Мян.төг		
	4			Татвар, хураамж, ашиг, эдийн засгийн үзүүлэлт	Мян.төг		
		1		Татвар ноогдох орлого	Сая.төг		
		2		Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	Сая.төг		
		3		Цэвэр ашиг	Сая.төг		
		4		Үйл ажиллагааны мөнгөн урсгал /жил бүр/	Сая.төг		
		5		Хөрөнгө оруулалтын дараах мөнгөн урсгал /жил бүр/	Сая.төг		
		6		Хөрөнгө оруулалтын дараах мөнгөн урсгал /өссөн дүнгээр/	Сая.төг		
		7		Өнөөгийн цэвэр үнэ, цэнэ (NPV, 10%)	Сая.төг		
		8		Өгөөжийн дотоод норм (IRR)	Сая.төг		
		9		Хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа	Сая.төг		
		10		Улс, орон нутгийн төсөвт оруулсан орлого	Сая.төг		
			1	Улсын төсөвт төлсөн албан татвар, хураамж, ноогдол ашиг	Сая.төг		
			2	Аж ахуйн нэгж байгууллагын орлогын албан татвар	Сая.төг		
			3	Гаалийн албан татвар	Сая.төг		
			4	Нэмэгдсэн өртгийн албан татвар	Сая.төг		
			5	Хүн амын орлогын албан татвар	Сая.төг		
			6	Ашигт малтмал ашигласны нөөц ашигласны төлбөр	Сая.төг		
			7	Ашигт малтмал ашигласны нөөц ашигласны нэмэлт төлбөр	Сая.төг		
			8	Тусгай зөвшөөрлийн төлбөр	Сая.төг		
			9	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	Сая.төг		
			10	Гадаадын мэргэжилтэн, ажилчны ажлын байрны төлбөр	Сая.төг		
			11	Агаар бохирдлын төлбөр	Сая.төг		
			12	Нийгмийн даатгалын шимтгэл (хувь хүн)	Сая.төг		
			13	Нийгмийн даатгалын шимтгэл (байгууллага)	Сая.төг		
			14	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл (хувь хүн)	Сая.төг		
			15	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл (байгууллага)	Сая.төг		
			16	Төрийн захиргааны байгууллагад төлсөн үйлчилгээний хураамж ба бусад төлбөрүүд	Сая.төг		
			17	Төрийн өмчийн ноогдол ашиг	Сая.төг		
			18	Орон нутгийн төсөвт төлсөн албан татвар, хураамж, ноогдол ашиг	Сая.төг		
			19	Үл хөдлөх хөрөнгийн татвар	Сая.төг		

			20	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	Сая.төг		
			21	Газрын татвар	Сая.төг		
			22	Ус ашигласны төлбөр	Сая.төг		
			23	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр	Сая.төг		
			24	Орон нутгийн төрийн өмчийн ноогдол ашиг	Сая.төг		
7				**Бусад мэдээлэл**			
	1			Төрийн захиргааны байгууллагаас			
		1		Хууль эрх зүйн		PDF	
		2		Бусад мэдээлэл		PDF	
	2			ААНБ-аас			
		1		Төр болон хувийн хэвшлээс авсан дэмжлэг, санхүүжилт, тайлан.		PDF	
		2		Татварын хөнгөлөлтийн талаарх мэдээлэл үр дүн.		PDF	
		3		Паркт нэгжээр орох гэрээ байгуулсан аж ахуйн нэгжийн жагсаалт.		PDF	
		4		Үйлдвэрийн техник, технологийн түвшний үнэлгээ.		PDF	
		5		Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан.		PDF	
		6		Байгаль орчны менежментийн төлөвлөгөө		PDF	
		7		Хөгжлийн төлөвлөгөө		PDF	
		8		Техник, технологийн түвшний үнэлгээ		PDF	